МЭДЭЭ · 2024 оны 6-р сарын 10

СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ҮЕ ШАТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛНА



Чингэлтэй дүүргийн прокурорын газраас Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран "Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөл, шийдвэрлэх арга зам" сэдэвт хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг Чингис хааны музейд зохион байгууллаа.

Зөвлөгөөнд Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, дүүргийн прокурорын газрын прокурорууд болон Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төв, Чингис хааны музей, Гаалийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын төлөөлөгчид оролцлоо.

Чингэлтэй дүүргийн прокурорын газраас хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийсэн, соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан гэх 2020 онд 1, 2022 онд 3, 2023 онд 9 хэрэгт хяналт тавьж, хуулийн дагуу шийдвэрлэсэн бол 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 3 хэрэгт хяналт тавьж ажилласан байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=ZotX0lgZ9us

Хэлэлцүүлгийн үр дүнд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-д өөрчлөлт оруулах, соёлын өвийн эд зүйлийн үнэлгээ гаргах журмыг боловсруулах талаар Соёлын яаманд санал хүргүүлэх, тус яамнаас 2024 оны гуравдугаар улиралд Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн талаарх нэгдсэн чуулганыг зохион байгуулахаар болсон байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1217